

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого, Зохицуулалтын Газар
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
ХХАХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХОРШООЛСОН ХЭЛБЭРЭЭР
НОГООНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ
ЗАМААР ӨРХИЙН АМЬЖИРГААГ
САЙЖРУУЛАХ (9192-МОН) ТӨСЛИЙН
НЭГЖИЙН ЗАХИРАЛ
Ц.БОЛОРЧУЛУУН ТАНАА

2020.04.27 № 06/1395
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн тооцсон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгж Төслийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал Ц.Болорчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 03-наас 2020 оны 4 дүгээр сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дугаар сарын 17-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж, Грант Торнтон аудит ХХК-ийн партнер Б.Осоргарав, аудитын менежер Б.Дэлгэрмаа, аудитор О.Уянга, туслах аудитор Э.Номинтуяа нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 09/02 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариаланч иргэн, хуулийн этгээдийг дэмжих, хүнсний ногооны тариалангийн ажлыг механикжуулах, дуслын усалгааны технологи нэвтрүүлэх, механикжсан зоорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг оршино.

Хүрэх үр дүн:

- Хоршоо хэлбэрээр ажиллах ногоочдын бүлгүүд байгуулагдана.
- Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой ногооны аж ахуй эрхлэх технологи, туршлага нэвтэрсэн байна.
- Ногоочдын бүлгүүд зах зээлд хүрэх боломж нэмэгдсэн байна.

Төслийн хэрэгжилт:

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгж нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяанд хэрэгжиж байгаа бөгөөд Азийн хөгжлийн банктэй Буцалтгүй тусамжийн гэрээг 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан. Төслийн нийт өртөг 3 сая ам.доллар, 2018 оны 10 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл Төв аймаг (Борнуур), Дархан-Уул аймаг (Орхон), Увс аймаг (Улаангом), Сэлэнгэ аймаг (Ерөө) зэрэг аймгуудад хэрэгжинэ.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 326 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журам”
- Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгж нь НББ хөтлөхдөө Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан "Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар", санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар”-ыг дагаж мөрдөж байгаа нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Диктум Фактум ХХК-ийн “Санхүүгийн программ” гэсэн программ хангамжийг ашигладаг байна.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн үр дүнгийн тайлангийн 2019 оны нийт зардал нь 723,317.9 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 14,466.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93,001.6 мянган төгрөгөөр буюу 20 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дүн нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	467,848.7	171,371.3	(296,477.4)
Үндсэн хөрөнгө	-	203,475.8	203,475.8
Нийт хөрөнгө	467,848.7	374,847.1	(93,001.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	467,848.7	374,847.1	(93,001.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	467,848.7	374,847.1	(93,001.6)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь нийт 226,335.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, болон төслийн үйл ажиллагаатай холбоотой гарсан бусад зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд авто тээврийн хэрэгсэл 156,079.6 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 49,481.7 мянган төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил 10,774.5 мянган төгрөг, программ хангамж 10,000.0 мянган төгрөг буюу нийт 226,335.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо /эзний өмч/ дансны үлдэгдэл 374,847.1 мянган төгрөг болж 93,001.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,418,568.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулах төсөв батлагдаж, 7.6 хувь буюу 108,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 92.4 хувь буюу 1,310,568.5 мянган төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 46,308.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 10,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 36,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 308.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

1. Төсөл нь 2019 онд Биет бус хөрөнгө буюу Санхүүгийн программ захиалгаар хийлгүүлсэн ба Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2. Төслийн түрээсэлж буй 200 м.кв оффисын байрны түрээсийн 1м.кв-ийн сарын тариф нь 45.0 мянган төгрөг буюу ТӨБЗГ-аас баталсан түрээсийн хязгаараас 15.0 мянган төгрөгөөр өндөр байгаагаас тайлант онд нийт 36,000 мянган төгрөгийн үр ашиггүй түрээсийн зардал гаргасан байна. Түүнчлэн Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 6 ажилтантай боловч 200 м.кв байр түрээсэлж байгаа нь олон улсын ажлын байрны орон зайн стандартад заасан 1 хүнд ногдох ажлын зай, талбайн хэмжээнээс хэт өндөр байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн дараагийн аудитаар зөвлөх үйлчилгээний байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилттэй холбоотой төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс тэдгээрийн үйл ажиллагаа, анхан шатны баримт болон холбогдох дэмжих баримтын хяналт, мониторингийн үйл ажиллагааг шалгана.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансны цахим хуудаст мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээлэл оруулахаас 77 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай дүгнэлт

Залруулагдаагүй 36,308.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 14,466.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах (9192-МОН) төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Аудитор нь санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Увс аймагт ажилласан томилолтын зардлын зам хоног болон байрны зардлын мөнгийг Улаанбаатар хотын зам хоног, байрны зардлын хэмжээгээр тооцон илүү олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 21.5-д "ТХН-ийн дотоод томилолтын удирдамжийг төслийн захирлаар батлуулж, төсвийг Сангийн сайдын баталсан жишгээр тооцно", мөн Сангийн сайдын 2018 оны 301 тоот тушаалын 1. "Төрийн албан хаагчийн албан томилолтын зам хоногийн зардлыг суманд 12,000 төгрөг, аймгийн төвд 14,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 16,000 төгрөгөөр, байрны зардлын хэмжээг суманд 14,500 төгрөг, аймгийн төвд 36,000, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 53,000 төгрөгөөр тус тус шинэчилсүгэй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох тушаал шийдвэр, журам зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаал болон Сангийн сайдын 2018 оны 301 тоот тушаалын хязгаарын хүрээнд томилолтын зардлыг тооцон олгох.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Увс аймгийн төвд буудлын зах зээлийн ханш 50.0-60.0 мянган төгрөг байдаг. Гэтэл Сангийн сайдын 2018 оны тушаалд заасан 36.0 мянган төгрөгөөр буудлын зардлыг тооцож олгох нь бодит амьдралд нийцэхгүй байсан тул орон нутагт томилолтоор ажиллаж буй ажилтнаа хохироохгүйн тулд бодит ханшинд дөхүүлэн уг тушаалд заасан хотын ханшаар буюу 53.0 мянган төгрөгөөр тооцож, томилолт олгосон. Хүлээн зөвшөөрсөн байна.

3.2. Шилэн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 77 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, мөн хуулийн 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Мэдээллийн ил тод байдал алдагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд төсвийн хөрөнгийг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэн тайлагнаж байх талаар зөвлөмж өгөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийн дагуу анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	467,848,720.52	171,371,290.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	467,848,720.52	171,371,290.40
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	467,848,720.52	171,371,290.40
31210	Төгрөг	-	8,483,676.46
31211	Төрийн сангийн харилцах	-	8,483,676.46
31220	Гадаад валют	467,848,720.52	162,887,613.94
31223	Арилжааны банк дахь харилцах	467,848,720.52	162,887,613.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	203,475,800.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	203,475,800.43
39200	Биет хөрөнгө	-	195,420,244.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	156,079,616.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(12,954,608.13)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	-	49,481,720.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,422,258.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	10,774,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(538,725.00)
39300	Биет бус хөрөнгө	-	8,055,555.56
39301	Программ хангамж	-	10,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,944,444.44)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	467,848,720.52	374,847,090.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	467,848,720.52	374,847,090.83
51	Засгийн газрын хувь оролцоо	467,848,720.52	374,847,090.83
51200	Хуримтлагдсан үр дүн	467,848,720.52	374,847,090.83
51210	Өмнөх үеийн үр дүн	-	467,848,720.52
51220	Тайлант үеийн үр дүн	467,848,720.52	(93,001,629.69)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	467,848,720.52	374,847,090.83

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	527,605,440.11	667,655,198.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	527,605,440.11	559,655,198.65
120	Нийтлэг татварын бус орлого	605,440.11	32,012,563.78
1200042	Туслах үйл ажиллагааны орлого (хүүгийн орлого)	605,440.11	7,134,267.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	24,878,295.85
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	24,878,295.85
122	Тусламжийн орлого	527,000,000.00	527,642,634.87
122002	Хандив тусламж /гадаад/	527,000,000.00	527,642,634.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	108,000,000.00
1310	Төвлөрсөн сангаас	-	108,000,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	108,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61,087,301.84	723,317,869.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,087,301.84	723,317,869.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,087,301.84	716,183,601.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	108,000,000.00
210304	Байрны түрээс	-	108,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,933,101.84	573,381,403.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,933,101.84	573,381,403.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,200.00	34,802,197.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,200.00	11,942,162.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	22,860,035.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7,134,267.93
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,134,267.93
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,134,267.93
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	466,518,138.27	(55,662,670.39)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,330,582.25	7,901,401.26
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,330,582.25	7,901,401.26
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	45,240,360.56
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	2,175,780.56
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	43,064,580.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	467,848,720.52	(93,001,629.69)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	528,936,022.36	1,110,625,623.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	528,936,022.36	1,002,625,623.32
120	Нийтлэг татварын бус орлого	1,936,022.36	474,982,988.45
1200042	Туслах үйл ажиллагааны орлого (хүүгийн орлого)	1,936,022.36	7,134,267.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	467,848,720.52
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	467,848,720.52
122	Тусламжийн орлого	-	527,642,634.87
122002	Хандив тусламж /гадаад/	527,000,000.00	527,642,634.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	108,000,000.00
1310	Төвлөрсөн сангаас	-	108,000,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	108,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,087,301.84	707,469,420.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,087,301.84	707,469,420.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,087,301.84	700,335,152.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	108,000,000.00
210304	Байрны түрээс	-	108,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,933,101.84	580,392,990.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,933,101.84	580,392,990.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,200.00	11,942,162.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,200.00	11,942,162.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7,134,267.93
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,134,267.93
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,134,267.93
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	467,848,720.52	403,156,202.43
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	237,510,532.73
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	237,510,532.73
2200	Дотоод эх үүсвэрээр	-	237,510,532.73
223001	Бусад хөрөнгө	-	40,841,590.91
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	196,668,941.82
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(237,510,532.73)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	5,725,620.70
14	Бусад эх үүсвэр	-	7,901,401.26
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	7,901,401.26
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	2,175,780.56
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	2,175,780.56
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	467,848,720.52	171,371,290.40
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	467,848,720.52	171,371,290.40
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	467,848,720.52	467,848,720.52
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	467,848,720.52	467,848,720.52
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(93,001,629.69)	(93,001,629.69)
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	374,847,090.83	374,847,090.83

Тайлбар: ТХН нь ХХАХҮЯ-наас Сангийн сайдын багцад шилжихдээ 2019 оны эхний хагас жилийн байдлаарх хуримтлагдсан үр дүнг Төрийн сангаас өгсөн чиглэлийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансад толилуулсан байна.

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,418,568,600.00	937,845,685.69	480,722,914.31	66.11%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	732,119,000.00	700,335,152.96	31,783,847.04	95.66%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,119,000.00	700,335,152.96	31,783,847.04	95.66%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,000,000.00	108,000,000.00	-	100.00%
210304	Байрны түрээс	108,000,000.00	108,000,000.00	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	591,459,900.00	580,392,990.60	11,066,909.40	98.13%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	591,371,600.00	580,392,990.60	10,978,609.40	98.14%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	88,300.00	-	88,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,659,100.00	11,942,162.36	20,716,937.64	36.57%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,659,100.00	11,942,162.36	20,716,937.64	36.57%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	686,449,600.00	237,510,532.73	448,939,067.27	34.60%
222001	Тоног төхөөрөмж	241,680,000.00	-	241,680,000.00	-
223001	Бусад хөрөнгө	444,769,600.00	237,510,532.73	207,259,067.27	53.40%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,418,568,600.00	635,642,634.87	782,925,965.13	44.81%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,000,000.00	108,000,000.00	-	100.00%
310001	Улсын төсвөөс санхүүжих	108,000,000.00	108,000,000.00	-	100.00%
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,310,568,600.00	527,642,634.87	782,925,965.13	40.26%
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,310,568,600.00	527,642,634.87	782,925,965.13	40.26%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	171,371,290.40	(171,371,290.40)	-

Тайлбар: Тайлант онд тоног төхөөрөмжийн худалдан авалт хийхээр төлөвлөгөөний дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулсан боловч тендерт оролцогч байгууллагууд шаардлага хангаагүй тул тендер шалгаруулалтыг 2020 онд дахин зарлахаар болсон байна. Үүнтэй холбоотой тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгээгүй ба энэ нь санхүүжилт буурсан шалтгаан болсон байна.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020-739-СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл 9192 МОН				мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Увс аймгийн томилолтын зардлын зам хоног болон байрны зардлын мөнгийг хотын зам хоног, байрны зардлын хэмжээгээр тооцон илүү олгосон байна.	308.0	Зөвлөмж өгсөн.	Төслийн зохицуулагч, Ерөнхий нягтлан бодогч	Б.Болорчимэг, Ж.Сүхгэрэл
2	Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 200м.кв талбай бүхий оффисын байр түрээсэлж байгаа нь нэг ажилтанд ногдох албан ажлын өрөөний дундаж талбайн хэмжээнээс хэт өндөр, 1 сарын түрээсийн төлбөр 45.0 мянган төгрөг буюу ТӨБЗГ-ын баталсан хязгаараас 15.0 мянган төгрөгөөр илүү буюу нийт 36,000 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.	36,000.0	Албан шаардлага хүргүүлж, Хязгаарлалттай дүгнэлт өгөх	Төслийн захирал	Ц.Болорчулуун
3	ТХН нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 77 мэдээллийг хугацаанд нь, 70 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн.	Төслийн зохицуулагч, Ерөнхий нягтлан бодогч	Б.Болорчимэг, Ж.Сүхгэрэл
Нийт дүн		36,308.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24

№ 02/213

Улаанбаатар хот

САГ- 2020/739/СТА-ТХН

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн түрээсэлж буй 200 м.кв оффисын байрны түрээсийн 1м.кв-ийн сарын тариф нь 45.0 мянган төгрөг буюу ТӨБЗГ-аас баталсан түрээсийн хязгаараас 15.0 мянган төгрөгөөр өндөр байгаагаас тайлант онд нийт 36,000 мянган төгрөгийн үр ашиггүй түрээсийн зардал гаргасан байна. Түүнчлэн Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 6 ажилтантай боловч 200 м.кв байр түрээсэлж байгаа нь Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-т заасан 1 хүнд ногдох албан ажлын өрөөний талбайн хэмжээнээс хэт өндөр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 2018 оны 1 сарын 9-ний өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны тэмдэглэлийн 1.1-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн 1м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг 30,000.0 (гучин мянган) төгрөгөөс ихгүй байлгах", Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-т заасан 1 хүнд ногдох албан ажлын өрөөний талбайн хэмжээ 8 ам метр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-ийг баримтлан ажлын байрны зохистой зай талбай бүхий оффис түрээсэлж ажиллах.

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichie_Kheree\Alban_Shaardlaaga\2020\0424SAG4.Docx

001080772

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн захирал Ц.Болорчулуунд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Ч.ДАШДАВАА

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ”

ХХК-ИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ПАРТНЕР


Н.ЭРДЭНЭЦОГ

АУДИТОР

О.УЯНГА

ЗӨВШӨӨРСӨН:
ХОРШООЛСОН ХЭЛБЭРЭЭР
НОГООНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ЗАМААР
ӨРХИЙН АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ

Ц.БОЛОРЧУЛУУН



Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.